



## ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/15

Улаанбаатар хот

### Удирдамж, арга зүйгээр хангах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.6, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.1, Засгийн газрын 2021 оны “Дүрэм шинэчлэн батлах тухай” 212 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 4.2.2, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/239 дүгээр захирамж, Газрын дүрмийн 4.1.7, 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Барилга байгууламж болон барилга байгууламжийн их засвар, шинэчлэлтийн ажлыг ашиглалтад оруулах комиссын ажлын гүйцэтгэл, үр дүнг сайжруулах зорилгоор комиссын ажлыг зохион байгуулах удирдамж, арга зүйг нэгдүгээр, барилга байгууламжийн гүйцэтгэлтэй танилцсан тухай илтгэх хуудасны загварыг хоёрдугаар, барилга байгууламжийн их засвар, шинэчлэлтийн ажлын гүйцэтгэлтэй танилцсан тухай илтгэх хуудасны загварыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Барилга байгууламж болон барилга байгууламжийн их засвар, шинэчлэлтийн ажлыг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг батлагдсан удирдамж, арга зүйн дагуу холбогдох хууль тогтоомж, стандарт, норм дүрэмд нийцүүлэн зохион байгуулж үр дүнг тайлагнаж ажиллахыг Барилга байгууламжийн хяналтын хэлтсийн даргад үүрэг болгосугай.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан газрын даргын А/82 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Орлогч дарга (О.Оджаргал)-д даалгасугай.

ДАРГА



С.ТӨМӨРДУЛАМ

1150500038

Газрын даргын 2022 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 115 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт




БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ ХҮСЭЛТИЙГ ШИЙДВЭРЛЭХ АЖЛЫН УДИРДАМЖ, АРГА ЗҮЙ

№	Ажлын үе шат чиг үүрэг	Гүйцэтгэх ажил	Хариуцах албан хаагч
1	Барилга байгууламж болон барилга байгууламжийн их засвар, шинэчлэлтийн ажлыг ашиглалтад оруулах хүсэлт хүлээн авах	ИААНБ-аас ашиглалтад оруулах тухай хүсэлтийг хүлээн авах, албан хаагчдад хуваарилах <a href="http://www.service.e-mongolia.mn">/www.service.e-mongolia.mn</a> <a href="http://www.edoc.ulaanbaatar.mn/">www.edoc.ulaanbaatar.mn/</a>	Хэлтсийн дарга
2	Хүсэлтийг судлах, шийдвэрлэх	<ol style="list-style-type: none"><li>Ирүүлсэн хүсэлтийн хавсралт, баримт бичгийн бүрдэл дутуу тохиолдолд хүсэлтийг буцаана.</li><li>Баримт бичгийн хавсралт бүрэн тохиолдолд тухайн барилга байгууламжийн гүйцэтгэлд газар дээр нь үзлэг хийж, илтгэх хуудсаар хэлтсийн даргад танилцуулна.</li><li>Барилгын ажлын гүйцэтгэл, баримт бичгийн бүрдэл дутуу, ашигласан нь тогтоогдсон тохиолдолд 3 хоногт багтаан илтгэх хуудсыг хавсарган албан бичгээр комиссын хүсэлтийг буцаана.</li><li>Барилга байгууламжийн мэдээллийг Орчны аюулгүй байдлын мэдээллийн санд оруулах заавар, зөвөлгөөг захиалагчид өгнө.</li><li>Илтгэх хуудсыг ирүүлсэн хүсэлттэй хавсарган хадгаламжийн нэгжид архивлах.</li></ol>	Хүсэлт хүлээн авсан албан хаагч
3	Барилга байгууламж болон барилга байгууламжийн их засвар, шинэчлэлтийн ажлыг ашиглалтад оруулах комиссын бэлтгэл ажлыг хангуулах	<ol style="list-style-type: none"><li>Хэлтсийн даргын гарын үсэг зурж баталгаажуулсан илтгэх хуудсыг газрын дарга, орлогч даргад танилцуулж, комиссын хуваарийн төсөлд тусгаж газрын дарга, орлогч дарга болон холбогдох Нийслэлийн Засаг даргын орлогчоор батлуулна.</li><li>Батлагдсан хуваарийг байгууллагын цахим хуудсанд долоо хоног бүрийн пүрэв гарагт байршуулна.</li><li>Бүрэлдэхүүн байгууллагуудын цахим хаяг руу батлагдсан хуваарийг илгээж гишүүн томилуулна.</li></ol>	Ахлах мэргэжилтэн

4	<p>Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг зохион байгуулах</p>	<p><u>Барилга байгууламж:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Комиссын бүрэлдэхүүн байгууллагуудаас ирүүлсэн комиссын гишүүдийн нэрсийг захиалагч, гүйцэтгэгч нарт цахимаар хүргүүлэх;</li> <li>- Комиссын хуралдааны тэмдэглэл хөтлөх, барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлтийг үйлдэх;</li> <li>- Орчны аюулгүй байдлын мэдээллийн санд бүртгэгдсэн барилга байгууламжийн мэдээллийг хянах;</li> </ul> <p><u>Барилга байгууламжийн их засвар, шинэчлэлт:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Комиссын үйл ажиллагааг зохион байгуулах талаар гүйцэтгэгчид зөвлөгөө, мэдээлэл өгөх;</li> <li>- Стандарт, норм дүрмийн хэрэгжилтийг хангуулах үүрэг даалгаврыг комиссын даргын саналд тусгах;</li> <li>- Орчны аюулгүй байдлын мэдээллийн санд бүртгэгдсэн барилга байгууламжийн мэдээллийг хянах;</li> </ul>	<p>Хүсэлт хүлээн авсан албан хаагч</p>
5	<p>Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт баталгаажуулах</p>	<ol style="list-style-type: none"> <li>1. Орчны аюулгүй байдлын мэдээллийн сангийн бүрдлийг хянаж, барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлтэд тэмдэг дарж баталгаажуулна.</li> <li>2. Комиссын даргын үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавьж нийт гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтийн гарын үсгийн баталгаажилтыг үндэслэн комиссын дүгнэлтэд дугаар олгож, тамга дарж баталгаажуулна.</li> <li>3. Байгууллагын архивын хадгаламжийн нэгжид хүлээлгэн өгөх комиссын дүгнэлт, комиссын хуралдааны тэмдэглэл, барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудас, ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэлийн хамт эх хувийг цаасан болон цахим архивын баяжилтыг хийнэ.</li> </ol>	<p>Хүсэлт хүлээн авсан албан хаагч</p>

Газрын даргын 2022 оны ... дугаар  
сарын ... ны өдрийн ... дугаар  
тушаалын хоёрдугаар хавсралт



**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН БАРИЛГЫН АЖЛЫН  
ГҮЙЦЭТГЭЛТЭЙ ТАНИЛЦСАН ИЛТГЭХ ХУУДАС**

20... оны ... сарын ... өдөр

Барилга байгууламжийн байршил: .....

Барилгын ажлын нэр, хүчин чадал: .....

Хүсэлт ирүүлсэн огноо, дугаар : .....

Захиалагчийн нэр, утасны дугаар: .....

цахим шуудангийн хаяг: .....

№	Үндсэн шаардлага	Тийм	Үгүй
1	Барилгын гадна заслын ажил бүрэн дууссан эсэх <i>/хана, тагтны хаалт, хашлага, галын шат/</i>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Инженерийн шугам, сүлжээнд холбогдсон эсэх		
	- Цэвэр, бохир усны хангамж	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	- Дулаан хангамж	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	- Цахилгаан хангамж	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	- Холбоо хангамж	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Өргөх байгууламжид хяналтын байгууллагын байцаагчийн үзлэг, туршилт хийсэн техникийн магадлалын акт баталгаажсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Барилгын дотор засал дууссан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээг хангасан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6	Орчны тохижилт бүрэн дууссан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
7	Орц, гарцыг зураг төслийн дагуу бүрэн хийсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
8	Зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлт байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
9	Захиалагчийн барилгын техникийн хяналтын нэгдсэн дүгнэлт байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
10	Барилгын ажлын зөвшөөрөлтэй эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
11	Барилгын захиалагчийн нэр шилжсэн тохиолдолд баримт, нотолгоог бүрдүүлсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
12	Газрын баримт бичиг зөрчилгүй эсэх <i>/Өмчилсөн газар: өмчиллөөс татгалзсан, өмчлөх эрхийн Улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болгосон, нийт талбайгаар зориулалтын дагуу зээмших эрх авсан байх/</i>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

	/Эзэмших газар: захиалагчийн нэр, барилгын зориулалтын дагуу, нэр шилжүүлсэн нотлох баримт/		
13	Орчны аюулгүй байдлын мэдээллийн санд барилга байгууламжийн мэдээлэл оруулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

ТАЙЛБАР: Дээрх үндсэн шаардлагын үзүүлэлтүүд бүгд хангасан, хангалтгүй гэж тэмдэглэгдсэн байх шаардлагатай. Хүснэгт №1. Шалгуур үзүүлэлтүүд

--	--

Зураг №1. Байршил, барилгын нүүр талын зураг

--	--

Зураг №2. Бусад

Жич: Барилгын орчны тохижилт, барилгын ажлын гүйцэтгэлийг гэрэл зургаар баталгаажуулж, тайлбар бичсэн байна.

Тайлбар: .....

.....

.....

.....

.....


.....

ТАНИЛЦСАН:  
 ГАЗРЫН ОРЛОГЧ ДАРГА ..... /...../  
 (гарын үсэг) (овог, нэр)

ХЯНАСАН:  
 ХЭЛТСИЙН ДАРГА ..... /...../  
 (гарын үсэг) (овог, нэр)

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:  
 МЭРГЭЖИЛТЭН ..... /...../  
 (гарын үсэг) (овог, нэр)

Газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 11-ны өдрийн 11/15 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ИХ ЗАСВАР, ШИНЭЧЛЭЛТИЙН  
АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛТЭЙ ТАНИЛЦСАН ИЛТГЭХ ХУУДАС**

20... оны ... сарын ... өдөр

Барилга байгууламжийн барилгын ажлын нэр: .....

Хүсэлт ирүүлсэн огноо, дугаар: .....

Захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлсэн байгууллага, хариуцсан инженерийн нэр: .....

Гүйцэтгэгч байгууллагын нэр: .....

№	Үндсэн шаардлага	Тийм	Үгүй
1	Барилгын ажил батлагдсан тоо хэмжээ, зураг төслийн дагуу бүрэн хийгдсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Өөрчилж хийсэн ажлын шийдвэр баталгаажсан эсэх /Захиалагч, зохиогчийн техникийн хяналтын нэгдсэн дүгнэлтэд тусгасан, хурлын тэмдэглэлээр баталгаажсан/	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Ногоон байгууламжийн ажил бүрэн хийгдсэн эсэх /Төсөв, зураг төсөлд ногоон байгууламжийн ажил тусгагдсан/	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлт байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Захиалагчийн барилгын техникийн хяналтын нэгдсэн дүгнэлт байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

**ТАЙЛБАР:** Дээрх үндсэн шалгах үзүүлэлтүүд бүгд тийм гэж тэмдэглэгдсэн байх шаардлагатай. Хүснэгт №1. Шалгуур үзүүлэлтүүд

--	--

Зураг №1. Байршлын зураг

--	--

Зураг №2. Бусад

Жич: Барилга байгууламжийн засвар, тохижилтын ажлын гүйцэтгэлийг гэрэл зургаар баталгаажуулж, тайлбар бичсэн байна.

Тайлбар: .....

.....

.....

.....

.....

ТАНИЛЦСАН:  
ГАЗРЫН ОРЛОГЧ ДАРГА ..... /..... /  
(гарын үсэг) (овог, нэр)

ХЯНАСАН:  
ХЭЛТСИЙН ДАРГА ..... /..... /  
(гарын үсэг) (овог, нэр)

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:  
МЭРГЭЖИЛТЭН ..... /..... /  
(гарын үсэг) (овог, нэр)